



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичигт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Үндэсний аудитын газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах салбарын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дагаж мөрдөхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /хурандаа Д.Ганбат/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1320100627

Батлан хамгаалахын сайдын 2020 оны

11. дугаар сарын 11.-ны өдрийн

11.2020 дугаар тушаалын хавсралт

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

4.2.5 Орлоготой холбоотой журналын бичилтүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах

Үндсэн үйл ажиллагааны орлого:

1. Мөнгөөр ороогүй боловч хоёр талын гэрээний дагуу эрх бүхий байгууллагын баталсан үнээр орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэх тохиолдолд:

ДТ- Бусад авлага /байгууллага, хувь хүмүүс/

КТ- Үндсэн үйл ажиллагааны орлогоор, (үйлчилгээний орлого)
/БХЯ-ын харьяа байгууллагууд /

КТ- Туслах үйл ажиллагааны орлогоор /ЗХЖШ, Төрлийн
цэргийн командлалуудын харьяа нэгтгэл, анги, салбарууд/

Туслах үйл ажиллагааны орлого:

Үндсэн цалингаас тушаалын дагуу суутган тооцсон сахилгын шийтгэлийн орлогыг:

Тохируулах бичилтээр:

ДТ- Цалингийн зардал

КТ- Өглөг / Байгууллагад төлөх/

Сахилгын шийтгэлийн орлогын бичилт :

ДТ- Мөнгөн хөрөнгө

КТ- Туслах үйл ажиллагааны орлого

1. Туслах үйл ажиллагааны орлого: / арьс, шир, ноос, ноолуур, байр орон сууцны хөлс, бусад/

ДТ- Мөнгөн хөрөнгө /Төрийн сангийн харилцах/

КТ- Туслах үйл ажиллагааны орлого

2. Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн төвлөрүүлэн захирагч, Төсвийн шууд захирагч нарын тушаал шийдвэр, Хөндлөнгийн болон Санхүүгийн хяналт шалгалтын актаар тогтоогдсон өр төлбөр, хувь хүмүүсийн буруутай үйлдлээс болон тооллого тооцоогоор бараа материал дутагдсаныг авлага үүсгэх тохиолдолд:

ДТ- Бусад авлага /байгууллага, хувь хүмүүсээс авах авлага/

КТ- Туслах үйл ажиллагааны орлого

4.6.4 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Түүх, соёлын эд өлгийн зүйлийг шинээр авахдаа Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм", Сангийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан "Түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам, үнийн жагсаалт"-ыг баримтална.

4.6.6 Үндсэн хөрөнгийн элэгдэл

Түүх, соёлын эд өлгийн зүйлийг элэгдэл, "Соёлын өвийг хамгаалах тухай" хууль, Монгол Улсын стандарт MNS5634:2006 "Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага"-уудыг баримтлан түүх соёлын дурсгалт зүйлийг 4 жил тутам Соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр тоолж, үзмэр, эд өлгийн зүйлийн чанар байдал /элэгдэл/-ыг тогтоон, тооллогын улсын комисст тайлагнана. Музейгээс сэргээн засварлах шаардлагатай дурсгалт зүйлийн жагсаалтыг жил бүр гаргаж, "Соёлын өвийг хамгаалах тухай" хуульд зааснаар сэргээн засварлах эрх бүхий мэргэжлийн байгууллагад саналыг хүргүүлэн, шийдвэрлүүлэх.

--oOo--